



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн  
баталгааны чиглэлээр хэрэгжүүлж буй  
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чиглэлээр гарсан хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах, эрчимжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдаас дараах албан даалгавар өгч байна:

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн яамны харьяа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт:

- 1.1. Сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх;
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагууд захиргаа, удирдлагын нэгжийн орон тоог нэмэхгүй байх;
- 1.3. 2018 оны төсвийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтнүүд, ялангуяа сувилагч нарыг ажлын дулаан хувцсаар хангах;
- 1.4. Эмч, сувилагч нарыг жижүүрт гарч байх үед эрүүл, чанартай хоолоор үнэ төлбөргүй хангах;
- 1.5. Эмнэлгийн мэргэжилтэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хөнгөлөлттэй үзүүлэх журмыг баталсан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 224 дүгээр тушаалын дагуу эмнэлгийн мэргэжилтэнд бүх шатлалын эмнэлэгт дараалал харгалзахгүй, төлбөрийн хөнгөлөлттэйгээр тусламж, үйлчилгээ авах боломж бүрдүүлэх;
- 1.6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуульд заасны дагуу батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, хэмнэсэн зардлыг ажилтны нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах үйл ажиллагаанд зарцуулах;
- 1.7. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудаас хуульд зааснаас бусад зорилгоор хураамж, хандив цуглуулахгүй байх;

080021

- 1.8. Сувилагч нарыг ажлын байрны тодорхойлолтод зааснаас бусад ажилд дайчлахгүй байх;
2. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захиралд:
  - 2.1. Түрээсийн болон ипотекийн орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй эрүүл мэндийн ажилтнуудын судалгааг 2018 оны 2 дугаар улиралд багтаан авч нэгтгэн, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах;
  - 2.2. Мэргэжлээрээ эргэн ажиллах хүсэлтэй сувилагч нарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөр боловсруулан яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар 2018 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлж, хэрэгжилтийг зохион байгуулахыг тус тус даалгаж байна.
3. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамцад, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус хариуцуулж байна.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ